МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 04 өдөр Дугаар А/150 Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт, төсөвт
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдана авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XXIII хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Мөрөн сум доторх зам засвар арчилгаа” худалдан авах ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

3.“Мөрөн сум доторх зам засвар арчилгаа” ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, батлагдсан төсвийн дагуу санхүүжилтийг олгож ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010451

Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр
сарын 4...-ний өдрийн А/150..дугаар
захирамжийн хавсралт

"МӨРӨН СУМ ДОТОРХ ЗАМ ЗАСВАР АРЧИЛГАА"
АЖЛЫН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖАГСААЛТ

| № | Үйл ажиллагаа | Тоо ширхэг | Шаардагдах хөрөнгө /Төгрөг/ |
|---|---|---|---|
| 1 | Давс, бодис нийлүүлэх зардал /зам арчлалт/ | 1 | 22,000,000 |
| 2 | "Мөрөн сумын хатуу хучилттай авто замын нөхөөс хийх ажлын зардалд | 1 | 78,000,000 |
| | Нийт дүн | | **100,000,00** |

________оОо________